



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар АМ

Хоад

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.5.1, 1.3.5.2 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хаврын өнгө-2019” үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад болон шилдэг шалгарсан бүтээгдэхүүнд олгох шагналд шаардагдах зардлын төсөв 3830.0 мянган төгрөг /Гурван сая найман зуун гучин мянга/ -ийг хавсралтаар баталж, төсвийг орон нутгийн хөгжлийн сангийн 5.33-д заасан брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, баталгаажуулах ажиллагааны санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 11-ний өдрийн
А/11 дүгээр захирамжийн хавсралт

“ХОВДЫН ӨНГӨ-2019” ҮЗЭСГЭЛЭН
ХУДАЛДААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Үзэсгэлэн худалдаанд шаардагдах зүйлсийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Урилга, хөтөлбөр	ш	150	600	90 000
2	Мандат	ш	150	2000	300 000
3	Анонс	мк	33	8 000	264 000
4	Сандал ширээ зөөх машины хөлс	ш	8 удаа	20000	160 000
5	Мандатны уут	ш	150	300	45 000
6	Энгэрийн тэмдэг	ш	30	10 000	300 000
7	Ширээ сандал түрээслэх	ш	50	6000	300 000
8	Анонс тогтоолгох олс	м	30	400	12 000
9	Талархал	ш	150	3000	450 000
10	Өргөмжлөл	ш	15	65000	975 000
11	Цом	ш	15	60000	900 000
12	Захын үзэлээр зар явуулах	хоног	2	20 000	40 000
	Дүн				3.830 000

-oOo-